



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 1/2025

Улаанбаатар хот

Болзошгүй үер, усны ослоос
урьдчилан сэргийлэх
бэлэн байдлыг хангуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал, Улсын Онцгой комиссын 2025 оны 02 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн иргэдийг болзошгүй үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, иргэд олон нийтэд мэдээлэл, сурталчилгааг шат дараатай зохион байгуулж, сэрэмжлүүлэх ажлыг эрчимжүүлэх, иргэдийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг дүүргийн Онцгой байдлын хэлтэс (хурандаа Б.Батбилэг)-т, хяналт шалгалтын ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Ажлын хэсгийн дарга, дүүргийн Менежер (Л.Цээрэгзэн)-т тус тус үүрэг болгосугай.

2.Дүүргийн нутаг дэвсгэрт үер усны аюулаас урьдчилан сэргийлэх хяналт шалгалт зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, шаардагдах зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар баталсугай.

3.Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх хяналт шалгалт зохион байгуулахад шаардагдах 2,635,500 (Хоёр сая зургаан зуун гучин таван сая таван зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг дүүргийн Засаг даргын Тамгын газар (О.Батмөнх)-т зөвшөөрсүгэй.

4.Төсвийн зарцуулалтад хяналт тавьж гүйцэтгэлээр санхүүжүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхбаяр)-т үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.МАНДУУЛ

1525010611